



**Дорнод аймгийн
сургагч багш нар
3 жилд**

2003-2004 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН



1. Багш нарт сургалт зохион байгуулах

"Байгаль орчны тулгамдсан асуудал" сэдвээр аймгийн төвийн ЕБС-иудын төлөөлөгч байгаль, нийгмийн ухаан, монгол хэлний 40 багшийг сургалтанд хамрууллаа.

ЕБС-ийн төлөөлөл 38 сурагчдыг хамарсан "Байгаль орчны тулгамдсан асуудлууд" сэдэвт сургалтыг Хэрлэн сумын V сургуульд зохион байгууллаа.

2. Судалгаа:

Хүрээлэн байгаа байгаль орчны талаарх сурагчдын мэдлэгийг тандах судалгаа, санал асуулгыг ЕБС-ийн 7-10 ангийн сурагчдын төлөөлөгчдөөс авч тэдний оролцоог хангахад чиглэгдсэн ажлуудыг төлөөлөн зохион байгууллаа.

Үүнд:

- Байгаль орчны боловсрол олгох хичээлийн чанарыг сайжруулах
- Экологийн асуудлыг бүх хичээлүүдээр интеграцчилан заах, арга зүйн зөвлөмж, сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- ЕБС-иудын нийгмийн ажилтнуудтай хамтран сургалт сурталчилгаа зохион байгуулах
- Бүх мэргэжлийн багш нарт экологи байгаль орчны талаар мэдлэг, мэдээлэл хүргэж, сургалтандаа хэрэгжүүлэх боломж олгох
- ЕБС-иудад үйл ажиллагаа явуулж байгаа байгаль экологийн клубуудын ажиллагааг идэвхжүүлэх.



100



3. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Сургалтанд хамрагдсан багш нарын дэмжлэгтэйгээр сургуулийн эцэг эхийн зөвлөлийн төлөөлөгчдөд "Байгаль хамгаалал орчны бохирдол" сэдэвт сургалт зохион байгуулав. Сургалтанд Хэрлэн сумын 7,9,6,5,10 багийн 52 хүнийг хамрууллаа.

4. Цэцгийн баяр

Хэрлэн сумын ЕБС, цэцэрлэгүүдийн дунд "1000 цэцгийн баяр" сэдэвт уралдаан зарлав. Уралдаанд Хэрлэн сумын V сургуулийн 2а, I сургуулийн 5б, XII сургуулийн 8а ангиуд эхний байруудад шалгарлаа.



5. Хог хаягдал

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, Мобикомын салбартай хамтран ЕБС-ийн 7-10 ангийн сурагчдыг хамруулан Хэрлэн голын эрэг орчмын хог хаягдлыг цэвэрлэж зайлуулах ажил зохион байгуулав.



6. Байгалийн ухааны багш нарын холбоо байгуулан сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулж байна.

2005-2006 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

1. Сургалт

- 2005.10.15 нд ЕБС-иудын байгалийн ухааны нэгдлийн багш нарт "Байгаль дахь хичээл заах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд хими, физик, газарзүй, биологийн 35 багш хамрагдаж Хэрлэн гол орчмын хог хаягдлыг цэвэрлэв.

Сургалтаар: Экологийн тулгамдсан асуудлаар

- Концерт эволюци кино
- Байгаль дахь хичээл зохион байгуулав.
- 2005.04.25-нд аймгийн цэцэрлэгийн 64 багшид "Байгаль дахь хичээл заах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулав.



Байгаль дахь сургалтанд оролцсон байгаль, нийгмийн ухааны болон цэцэрлэгийн багш нар

2. Уралдаан тэмцээн

2005.09.25-нд ЕБС-иудын 9-10 ангийн багш сурагчдын дунд "Орчны бохирдол хог хаягдал" сэдэвт тэмцээнийг зохион байгуулав. Тэмцээнд V, XII, I, XI, Хан-Уул цогцолбор сургуулиуд оролцож 1-р байр XII, 2-р байрыг I, 3-р байрыг XI сургуулиуд эзэлж дурсамж мөнгөн шагналаар шагнуулав.

Сургалтын дүнд сурагчид:

- Хог хаягдлыг ангилж, эрүүл орчин бүрдүүлэх
- Байгаль орчны бохирдлыг багасгахад өөрийн хувь нэмрээ оруулах, зөв сэтгэлгээ төлөвших
- Мэтгэлцээний аргад суралцав

2005.05.31-нд

"1000 цэцгийн баяр" үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.



"Орчны бохирдол, хог хаягдал" сэдэвт тэмцээн

3. Цэвэр орчин бүрдүүлэх

Сар бүрийн 3 дахь долоо хоногт ЕБС-иудын 7-10 ангийн багш сурагчид Хэрлэн голын эрэг орчмын хог хаягдлыг цэвэрлэж хэвшив.



4. Хөтөлбөр боловсруулах

Аймгийн ЕБС-иудын биологийн багш нартай хамтран "Дорнод аймгийн эмийн ургамал сэдэвт интеграцчилсан хөтөлбөр боловсруулж хичээлээр туршин зааж хэрэгжүүлэв. Мөн "Дорнод аймаг дахь эмийн ургамлууд" сэдэвт герибарын уралдаан зарлаж V сургуулийн багш Б.Уранжаргал шалгарав.



"Интеграцчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй" сэдэвт сургалтанд оролцсон багш нар

5. Байгаль экологийн талаарх мэдлэг ойлголтыг бусад хичээлүүдээр интеграцчилан заах сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй" сэдвээр янз бүрийн мэргэжлийн багш нарт сургалт зохион байгууллаа.



**2006-2007 ОНД
ЗОХИОН
БАЙГУУЛСАН
АЖИЛ**

**Дорнод аймгийн
сургагч багш нар
3 жилд**

Сургалт

"Ургамалжилт-агаарын бохирдол" сэдвээр Шинэ хөгжил, VI сургуульд, "Орчны бохирдолт хог хаягдал" сэдвээр Хэрлэн сумын V сургуульд, "Дэлхийн цаг агаарын өөрчлөлт" Хэрлэн сумын II сургуульд, "Хөрсний бохирдол" сэдвээр VI, "Тогтвортой хөгжил-ногоон сургууль" сэдвээр XII сургуульд сургалт зохион байгууллаа. "Байгаль дахь хичээлийг бага насны хүүхдэд зохион байгуулах нь" сэдвээр Хэрлэн сумын 8 цэцэрлэгийн багш нарт зохион байгууллаа.



Хэрлэн сумын V сургуульд зохион байгуулсан сургалт



Хэрлэн сумын XII сургууль "Тогтвортой хөгжил-ногоон сургууль" сэдвээр сургалт



"Янзага" төслид хамрагдсан сургагчдын байгаль орчинтой танилцах "Үүрэгчтэй аялал" сургалт.

Дорнод аймгийн Байгаль орчны албанаас хэрэгжүүлсэн "Янзага" төслийн хүрээнд аймгийн ЕБС-иудын Байгаль экологийн клубуудын үйл ажиллагааг дэмжиж, доорх ажлуудыг хийлээ.

- Сургууль болон ангиа цэцэгжүүлэх
- Хог хаягдлыг ангилж сурцага
- Хоггүй орчинд амьдарцага сэдвүүдээр уралдаан тэмцээн зохион байгуулж, ханын сонин, зурагт хуудас, зурсан зураг болон фото зургийн үзэсгэлэн гаргасан байна.



Хэрлэн сумын ЕБС-иудын байгаль экологийн клубуудын нээгдсэн цугларалт "Байгаль дахь хичээл"-ийг Хэрлэн голын эрэгт зохион байгуулсан нь.

Хэрлэн сумын V сургууль

"Green house", XII Сургуульд "Байгаль хамгаалал", I сургууль "Бөөдий", Хан-Уул цогцолбор "Цагаан эзэр", XI сургуульд "Навчхан", Шинэ хөгжил цогцолбор "Өсвөрийн байгаль хамгаалагчид", VIII сургууль "Ногоон сургууль", II сургуульд "Залуу байгальчид" нэртэй экологийн клубууд үйл ажиллагаа явуулж байна.

КЛУБУУДЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Ханын сонины уралдаан
- Байгалийн ухааны хичээлүүдийн аварга сурагчид шалгаруулах
- Танин мэдэхүйн АХА тэмцээн
- Мэдээллийн цомог
- Байгаль экологийн холбогдолтой гарын авлага боловсруулах
- Экологийн хичээлийн кабинет байгуулах

"Байгаль ба хүүхэд" сэдвээр ханын сонин уралдаан



- Эцэг эхийн дунд "Байгаль экологийн асуудалд бид хамтдаа" сэдвээр өдөрлөг сургалт зохион байгууллаа.
- Сургууль орчноо зүлэгжүүлэх, ногоон хотхон байгуулах бэлтгэл ажлыг хийж эхлээд байна.
- Булган, Хөлөнбуйр, Дашбалбар, Матад, Чулуунхороот, Сэргэлэн сумдад хүүхдийн үүсгэл санаачлагаар Экологийн клубууд ажиллаж байна.



Хэрлэн сумын XI сургуулийн эгдөөд орчны цэцэгжүүлэлт



Матад, Хэрлэн сумын V сургуулийн экологийн клубын гишүүд

ЕБС-иудын түүх нийгмийн ухааны багш нарын дунд "Түүхэн дурсгалт газрууд" сэдвээр сурган хүмүүжүүлэх уншлагын уралдаан зохион байгуулж, олны хүртээл болголоо. Үүнд: Хэрлэн сумын V сургуулийн багш Г.Цэрмаагийн "Буриад ястны зан заншил байгаль хамгаалах уламжлал" сэдвээр илтгэл шалгарсан байна. Уралдаанд 28 багш оролцлоо.



**Хөвсгөл аймгийн
сургагч багш нар ямар
сэдэв хондөв**

**СЭДЭВ: Чоно хүн болон
байгалийн дайсан мөн үү?**

Нийгмийн хэрэгцээ: Дэлхий дээр байгаль цаг уурын өөрчлөлт болон хүний нийгмийн хөгжил, хүн амын хэт өсөлтөөс болж амьтдын амьдрах орчин хумигдан, амьтдын зүйлүүд ба тоо толгой маш хурдацтайгаар цөөрч, нэлээд амьтад мөхөж, зарим нь мөхлийн ирмэгт тулаад байна. Монгол оронд ч энэ байдал давтагдаж, хүмүүсийн шуналын золиосоор олонхи ан амьтад сүйрлийн ирмэгт хүрээд байна. Үүний учир шалтгааныг ойлгож, ан амьтдын байгаль дахь үүрэг, ач холбогдлыг ойлгуулж, тэднийг хайрлан хамгаалах үзэл санааг хүүхэд багачууд, ард иргэдэд төлөвшүүлэх нь хамгийн чухал асуудлуудын нэг болж байгаа билээ.

Хувь хүний хэрэгцээ: Чоныг хүн малын дайсан, алж устгасан хүний аз хийморийн од сэргэдэг гэж үзэн, алж устгахаар мөнгө амлан дайрч байгаа билээ. Хүн бүр ан амьтадаа шунал, бардамналын золиос болгожгүй харин байгаль, ан амьтдын харилцан шүтэлцээ, амьдралын онцлогийг судлан мэдэж, тэднийг хайрлан, бахархан биширч, харж сонирхон алжаалаа тайлдаг болох үзэл санааг бий болгох нь чухал болж байна.

Хичээлийн зорилго: Чонын амьдрал, түүний биологийн бүлгэмдэл дэх харилцаа холбоо, түүний устсанаас үүсэх хор хөнөөлийн тухай ойлгуулах

Зорилтууд:

К-1. Чонын амьдрал, ан амьтдын хоорондын харилцааны тухай мэдлэг эзэмшинэ

К-2. Чонын хоол тэжээлийн хэмжээ, ан амьтдын амьдын жин, орон зайн байршил, амьдран орших нутгийн талаар тооцоолол, загварчлал хийх, тэдний амьдрах боломжит хоол тэжээлийн хэмжээг тогтоох

К-3. Амьд амьтдын хоорондын холбоо, харилцан ашигтай байдал, чонын экосистемд үзүүлэх ач холбогдлыг мэдүүлэх, мал сүргээ чононоос хамгаалах арга барил эзэмшүүлэх

К-4. Чонын амьдран орших бүлгэмдлийг хамгаалах, чоныг хамгаалсны үндсэн дээр экологийн бүлгэмдлийг хамгаалах дадал, ухамсар төлөвшүүлэх



Хэрэглээдэхүүн: Ой модтой баялаг уулын зураг 2ш, 2 буга, 1 хандгай, 4 хүдэр, 5 гахай, 10 бор гөрөөс, 1 баавгай, 20 туулай, янгир, аргал, ойн цаа буга, бүргэд, 2 үзүүлэнгийн хадаас

Арга:

- Чонын тухай өмнөх мэдлэгийг сэргээхэд булангийн арга
- Ан амьтны байршил, амьдралын онцлогийг эвлүүлэг, загварчлалын арга
- Ан амьтдын тоон харьцаа, идэш тэжээлийн нормыг тогтооход статистикийн арга /тооцоолон бодох/
- Ан амьтад ховордооны учир шалтгааныг тогтооход хэлэлцүүлгийн арга
- Чонын тухай шинжлэх ухааны мэдлэг олгоход мэдээлэл солилцооны аргыг хэрэглэнэ

Хичээлийн явц, үйл ажиллагаа:

Чоно хоногт 30 км, хэрэгцээ тохиолдсон үед 50-60 км ч хол аялдаг. Өлссөн үедээ 10 кг, дунджаар хоногт 2 кг мах иддэг. Бэлтрэгээ 60-65 хоног тээж, 4-5-р сард 3-4, заримдаа 10-13 тооны бэлтрэг төрүүлдэг. Бэлтрэг нь 3 сартай болоод огтоно туулай барьж эхлэх ба бие гүйцсэн чоно ихэвчлэн хандгай, буга, бор гөрөөс, баавгай, хүдэр, аргаль янгир, цаа буга зэрэг амьтдыг ялангуяа үр төл байхад нь буюу хөгширч өвчилсөн үед нь барьж иддэг. Чоно 6-10-аараа сүрэглэх ба 2 настайгаасаа үржилд орно. Ой тайгад 1000 га-д 1 чоно, тал хээрийн бүсэд 2500-10000 га-д 1 чоно ноогддог. Чоно ой тайгын бүсийн бартаа саадтай газар хүний хөлөөс зайдуу нутагладаг.

Чоно хөгширч, өвчилсөн, хүч тамир дорой амьтдыг барин идэж, хүрээлэн буй орчныг цэвэрлэн, амьтдын тоо толгойг зохицуулдаг. Амьтад хэт их өсөөл, бэлчээр доройтох, халдварт өвчин гарах зэрэг хор нөлөөг байгальд учруулна.

Чоно бол байгалийг цэвэрлэгч, байгалийн шүүлтүүр юм.

Өвсөн тэжээлтэн амьтад нь гэрийн тэжээмэл ба зэрлэг амьтан гэсэн 2 хэсэгт хуваагдана.

ОН	Өвсөн тэжээлтэн амьтны тоо толгой	Гэрийн малын тоо толгой
1940	15 800 000	26 204 000
1986	10 814 810	28 600 000
2000	7 660 000	31 000 000
2005	4 263 370	30 000 000

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багш

Суралцагсдыг 4 баг болж хувааж, баг бүрт дараахь даалгаврыг өгнө. Үүнд:

- Чонын тухай үлгэр, домог ярианаудаас ярих
- Чонотой холбоотой зүйр цэцэн үг зохиох, хэлэх
- Чонын ашигтай талуудыг жагсаах
- Чонын хор холбогдолтой талуудыг харуулсан жагсаалт гаргах (10 мин)

Чонын тухай үлгэр сонсож, залуулж хийх үлгэр. Эрт урьдын цагт цэцэг нэгэн дэлгэрч, гол ус хөржингөн ой мод найгасан. Баянхайрхан гэдэг нэгэн сайхан уул байжээ. Тэр уулын ангар бэлээр Балбар гуайн мал сүрэг идэжшилж, бэлээс дээш ойн зах, ой тайгаар 2 буга, 1 хандгай, 4 худар, 5 гахай, 10 бор гөрөөс, 1 бээвэгэй, 20 туулай зэрэгцэн амьдардаг байжээ. Харин ойгоос дээш хад эгсанд нь 2 янгир, 2 эргэл, 1 цаа буга амьдарна. Гэтэл модтой уулын эр шилд 2 чоно үүрлэж, тэр хамийн ан амьтнаар зоог хийдэг байжээ. Уулын чанж оройд нэгэн бүргэд өлөн хэлин нисч, чонын бэлтрэг, үнэг, хулгана зурмаар хооллон амьдарна. (5 мин)

Үлгэрт заагдсанаар баг бүрээс 2 хүүхэд гарч, амьтдын дүрсүүдийг уулын зонх буслуурт бэйрлүүлнэ. (5 мин)

Дараахь даалгавруудыг баг багаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. Чоно өдөрт дунджаар 2 кг мөх иддэг. Тэгвэл 2 чоно жилд хэдий хэмжээний мөх идэхийг тооцоолно
2. Ууланд амьдарч байгаа бүх өвсөн тэжээлтэн зэрлэг амьтдын махны гарцын нийлбэр жинг гарга.
3. Чоно өөрийн чадамгаараа идэхэд ууланд хэдий хэмжээний мөх үлдэх вэ?
4. Чоно нэг жилд ямар ямар амьтдыг идэхэд хэмжээ нь тохирох вэ? Хувицбаруудыг гарга (5 мин)

Үлгэрийг үргэлжлүүлнэ. Ийнхүү байгалийн харьцаа тогтож, чоно гөлгөлөхөд бүргэд бэлтрэгийг идэж, өвсөн тэжээлт зэрлэг амьтад зулзагалж төллөхөд чоно тэдгэрийг нь барьж идэх буюу доройтож муудсан, хөгширсөн, өвчилсөн амьтдыг барьж идэх хоолоо болгож, уулан дахь амьтад тоо толгойгоо хадгалсаар он жилүүдийг үдэж өнөө үеийг хүрчээ. Гэтэл Балбар гуайнд өмнө зүгийн Хятад орноос маш их мөнгөтэй нэгэн худалдаачин ирж худрийн зээр, бээвэгэйн доньд, бээвэгэйн сая, бугын цусан асар, солсоны сая, янгир, аргалын асар, янгирин цус худалдан авч, бор гөрөөсийн цусыг уухаар 5 бор гөрөөс алуулав. Эдгээр хоёр нандин эмийн түүхий эдийг агуулдаг амьтдыг Балбар гуай хүүдүүдтэйгээ хамтарч хэдхэн сарын дотор агнаж дуусгалаа. Ууланд эдгээр хоёр нандин түүхий эдийг агуулаагүй хандгай, цаа буга, хэдэн бор гөрөөс, туулай зэрэг цөөн тооны амьтад үлдээв. Даалгавар. (3 мин)

Эдгээр амьтдыг 2 чоно барьж идэж дуусгалаа. Ийнхүү хоолгүй болсон тул 2 чоно гурихлан идэш хоол хайж энд тэндгүй гүйдэллээ. (3 мин)

Үлгэрийн үргэлжлэл. Ингээд 2 чоно Балбар гуайн сүргээс хэдэн адуу, хонь мал барьж идсэн учир Балбар гуай 2 хүүтээ дагуулан хурдан бую алч мөрдөн хоосвор 1 чоныг авчлаа. Ганцаар үлдсэн чоно ууланд барьж идье гэх хоол тэжээлгүй, уулын бэл рүү бууж, хонь мал барьж идье гэтэл Балбар гуайгаас айгаад очиж чадалгүй холуур гүйж, хотыг тойрч хад хонгод бүтэлгүй болсон тул буцаж үүр нь хол тул ядарч сульдан шолшиж ялаа. Ганц салхи исгаран шуулж, дээрээс харанхуйлан ирэхийг харвал уулын оройн хөгшин хүрэн бүргэд байлаа. Чоно ч хөл мэдэн зугтсаар сульдаж шүргэн унаа. Бүргэд ч өнөөдрийн хоолтой боллоо. Эцсийн чоныг барьснаас хойш хөгшин хүрэн бүргэд хоол ололгүй явсаар алч эцсийн замдаа оджээ. Түүнээс хойш Баянхайрхан ууланд охиод ямар ч чимээ шуулиангүй нам гүм, ан амьтадгүй болсон тул гол горхи уйтгайхан хөржингөн урсч, ой мод, наачин гүмтэйтгээн сэрчингөн бөхөлзөнө. (3 мин)

Асуултууд

- Ийнхүү Баянхайрхан уул ганд ч амьтангүй болсны буруутан хэн бэ? Чоно ямар буруу үйл хэрэг хийв?
- Чоно яагаад айлын хонь, адуу мал барьж ахлав?
- Чоныг алж устгах хэрэгтэй юу?
- Чоно хүн, байгалийн дайсан уу? (5 мин)

Чоно бол Дэлхийд устгах байгаа, Монгол оронд олноор үлдэж хоцорсон цэрын гэнц зарлаж арвантан амьтан юм.

Төгсгөлд нь ан амьтантай байлаг уул, амьтангүй болсон хоосорсон уулын зургаг загварыг харьцуулж, бид байгальд ямар гэмт нүгэл учруулдаг байгаагаа дүгнэнэ. (3 мин)

Балгасаа чонын амьдралтай холбоотой зарим мэдээлэл өгнө. (10 мин)

Үнэлгээ: Өөрсдийн үнэлгээ хийлгэх

Энэ талаар хир сайн ойлголттой болов гэсэн үнэлгээг цаасан дээр бичин тарааж үнэлүүлнэ. (3 мин)

Чоныг алж устгах урелдаан зарлаж байгаа нь зөв үү?

Тэр хүн байгальд унахээр ашигтай үйлдэл хийж чадаж байна уу?

- Гэрийн даалгаварт чи Байгаль орчны сайд байсан бол чонын талаар ямар арга хэмжээ авч явуулах вэ?
- Байгаль хамгаалагчид Чонын өвөг зохион байгуулах нь зөв үү? (1 мин)

Оралцагч

Баг бүр жагсаалт гаргаж, 1 оралцагч илтгэнэ.

Суралчид анхаарлаа тоолоруулэн сонсоно.

Суралцагчид амьтдыг ууланд бус буслуурээр, сүрлийн бүтцээр бэйршуулна.

Хүүхэд бүр тооцоог хийж, хамгийн оновчтой хувилбарыг сонгоно.

Оралцагчид үлгэрийг сонсоод үлгэр гарсан үнэт зүйлс ямар амьтад байдгийг ярилцана.

Эдгээр үнэт зүйлсийг хэрхэн авч болох талаар ярилцана. Үлдсэн амьтдын амьдын жинг тооцоолон гаргаж, чонын идэш хоол хүрэлцэртэй эсэхийг тооцоолно. Эдгээр алагдсан амьтдыг баг бүрээс 1 суралч гарч, зуралцаас авна.

Үлгэрийг үргэлжлүүлэн сонсоод асуултын дагуу ярилцана.

Суралчид дүгнэлт гаргана.

Мэдэрллийг сонсож, тэмдэглэл хийнэ.

Суралчид чонын амьдралын талаар ямар ойлгоцтой болонгоо нэг агуулбарээр илэрхийлнэ.

Байгаль орчны сайд, байгаль хамгаалагч, анхдад нээлттэй захидал бичиж сонинд нийтлүүлнэ.

№	Амьтны нэр	1996 оноос өмнө	Одоо
1	Хүдэр		
2	Буга	200000	50000
3	Хар сүүлт	60000 /1995/	100000
4	Гөрөөс	800000	100 000
5	Хандгай/Хавсаалд	100001200	2000200
6	Эзэр		
7	Хавтгай	320 /1995/	50-60
8	Гахай	1400 /1993/	400
9	Бөхөн	1500 /1970/	400 /1996/
10	Аргаль	40000 /1978/	10 000
11	Ойн цаа буга	400-500 /1996/	50-60
12	Янгир /Хөвсгөлд/	1050 /1981/	150
13	Тарвага	10 сая	4-5 сая
	Нийт тоо толгой	814810	283 370

← Зэрлэг амьтдын тоо толгойн хэлбэлзэл



**Булган аймгийн
сургагч багш нар ямар
сэдэв хөндөв**

Сэдэв: Агаарын бохирдол ба түлш

Хугацаа: 30 мин

Хамрах хүрээ: 9-р ангийн суралцагчид

Зорилго: Агаарын бохирдлыг үүсгэгч хүчин зүйл болох түлшүүдийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг багасгах арга замыг тодорхойлох

Зорилт:

1. агаарын бохирдолд нөлөөлөх түлшүүдийг тодорхойлох
2. түлшний агаарыг бохирдуулах байдлыг харьцуулан судлах
3. агаарыг бохирдуулах нөлөөллийг багасгах арга замуудыг тодорхойлох
4. агаарыг бохирдуулахгүй байх үзэл хандлагыг төлөвшүүлэх

Арга зүй: Тогтвортой хөгжлийн төлөөх сургалтын аргууд /багаар ажиллах, жагсаалт гаргах, зэрэглэх, мэтгэлцээн/

Хэрэглэгдэхүүн:

- сонголтын даалгавар-40ш
- жагсаалтын хуудас-8ш
- бохирдлыг багасгах арга замыг тодорхойлох хуудас

Хичээлийн явц:

- сонгох даалгавар бүхий хуудас тараан сонголт хийлгэнэ.

Танай гэрт хэрэглэдэг түлш агаарын бохирдолд нөлөөлдөг үү?

1 2 3 4


огт үгүй маш их

- сонголтоороо баг болж ярилцана
- агаарын бохирдолд нөлөөлдөг түлшнүүдийн жагсаалтыг гаргуулна

"Агаарын бохирдолд нөлөөлдөг ямар ямар түлш байдаг вэ?"

- багш жагсаалтыг нэгтгэн гаргана
- жагсааж бичсэн түлшнүүдийг агаарын бохирдолд нөлөөлөх байдлаар нь зэрэглэн ярилцана.
- Хамгийн ихээр нөлөөлдөг нүүрс гэдгийг тодорхойлуулна.

- Баримт уншина. Булган суманд жилдээ 10000 тн нүүрс хэрэглэдэг. Үүнээс хичнээн хэмжээний угаарын хий /CO/ ба нүүрс хүчлийн хий /CO2/ агаарт цацагдах вэ?
- Тооцоолбол: /тооцоог суралцагчдаар хийлгэнэ/



- ийм их хий агаарт цацагдаж байгаа учир нүүрсийг түлэхээ болих уу? яах вэ? гэдэг асуудал дэвшүүлэн ярилцаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлуулна. Үүний дараа энэ асуудлыг шийдвэрлэхэд "би", "манайх", "ард иргэд", "төр засаг" юу хийж чадах /болох/ вэ? гэдгийг баг бүрээр тодорхойлуулна.

Дүгнэлт: Агаарын бохирдлыг багасгахад миний оруулах хувь нэмэр сэдвээр ярилцаж дүгнэнэ.



Үндэсний зөвлөгөөн болов

RAMBOLL

Ramboll Natura AB



Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг (SIDA)-ийн санхүүжилтээр 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж ирсэн "Байгаль орчны боловсрол" төслийн хүрээнд "Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол" сэдэвт Үндэсний зөвлөгөөн 2007 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Чингис хаан зочид буудалд болов.

Уг зөвлөгөөнийг БСШУЯ, БОЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Шведийн Ramboll Natura AB зөвлөх компани хамтарч зохион байгуулав.

Зөвлөгөөнд аймгийн үндэсний сүлжээний болон загвар сургуулиудын сургагч багш нар-140, аймгийн Боловсрол, соёлын газрын дарга нар-22, загвар сургуулиудын захирлууд-9, Боловсрол, соёлын газрын арга зүйчид-22 нийт 200 гаруй хүмүүс оролцлоо. Мөн төр, захиргаа, олон нийт, олон улсын байгууллага, их дээд сургууль, гадаадын донор байгууллагын 30 гаруй хүмүүс урилгаар оролцов.

"Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол" Үндэсний зөвлөгөөний нээлтийн ажиллагаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд С. Төмөр-Очир, Байгаль орчны дэд сайд Б. Энхмандах нар оролцогчдод хандаж үг хэллээ. Мөн БСШУЯ-ны бага, дунд боловсролын газрын дарга Г. Батболд, тус газрын мэргэжилтэн Ц. Луасандорж, БОЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т. Эрдэнэбилэг, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захирал Б. Чимэд-Очир нар илтгэл тавилаа.

Ховд аймгийн Дөргөн, Мянгад, Чандмана сум, Увс, Баян Өлгий аймгийн загвар сургуулийн сургагч багш нар тогтвортой хөгжлийн боловсрол олгох орон нутгийн сургуулийн хөтөлбөрөө танилцуулж туршлагаа хуваалцлаа. Зөвлөгөөнд оролцогчид уриалга гаргалаа. Зөвлөгөөний төгсгөлд аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газруудын дунд зарласан "Байгаль орчин ба тогтвортой хөгжил" сургалт зохион байгуулах уралдааныг дүгнэж 1,2,3 байр эзэлсэн Ховд, Завхан, Нийслэлийн Боловсрол, соёлын газарт батламж, мөнгөн шагналыг гардуулав.

"Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол" үндэсний зөвлөгөөнөөс гаргасан уриалга

Эх болсон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, түүнтэй зохистой харьцах арга ухааныг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, тогтвортой хөгжлийн талаарх бүх нийтийн мэдрэмж, ойлгоцыг сайжруулах, тэдэнд шинэ хандлага, соёлыг төлөвшүүлэх нэгэн зорилгын дор төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллага ухварал, сэтгэл зүтгэлээр нэгдэн дор дурдсан чиглэлээр нягт хамтран ажиллахыг уриалж байна. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын талаархи бүх нийтийн мэдрэмж, ойлгоцыг гүнзгийрүүлж, хүний нэвцгийн үндэсний чадавхийг нэмэгдүүлэх
- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын агуулга, арга зүйг тогтоох, сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, орчныг бүрдүүлэх
- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, оролцоо дамжлагийг нэмэгдүүлэх
- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын агуулгыг сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд, дээд боловсролын албан ба албан бус сургалтын хөтөлбөрт тусгах, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тогтоох
- Эх болсон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, түүнтэй зохистой харьцах арга ухаан, шинэ соёл, хандлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Ногоон сургууль" хөдөлгөөн өрнүүлэх

"Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол" үндэсний зөвлөгөөнд оролцогчид

Улаанбаатар хот
2007 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр





“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛ” СЭДВЭЭР 6 ДАХЬ ЭЭЛЖИТ СУРГАЛТ - СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (SIDA)-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн төлөх боловсрол” төслийн ээлжит 2 өдрийн сургалт-семинар 2007 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд Олон улсын хүүхдийн “Найрамдал” теэд зохион байгуулагдлаа. Тус сургалт-семинарт нийт 190 гаруй хүн оролцсоноос аймаг, нийслэлийн үндэсний сүлжээний болон загвар сургуулиудын сургагч багш нар-140, аймгийн Боловсрол, соёлын газрын дарга нар-22, загвар сургуулиудын захирлууд-9. Боловсрол, соёлын газрын арга зүйчид тус тус хамрагдав.

Энэхүү сургалт-семинарын үеэр Боловсрол, соёлын газруудын дарга нарт “Тогтвортой хөгжлийн төлөх боловсрол”-ын талаар Шведийн зөвлөх багш нар мэдээлэл хийж, цаашид аймаг орон нутагтаа Тогтвортой хөгжлийн төлөх боловсролыг хөгжүүлэх талаар санал бодлоо солилцсон байна.

Баянхонгор, Булган, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн үндэсний сүлжээний сургагч багш нар байгаль орчны асуудлыг хөндсөн үлгэрчилсэн хичээлийг бусад оролцогчдод зааж сонирхууллаа.

Оролцогчид багаар ажиллан “Тогтвортой хөгжлийн төлөх боловсрол”-ыг цаашид хэрхэн хөгжүүлэх талаар ярилцлаа.

Аймгийн үндэсний сүлжээний болон загвар сургуулиудын сургагч багш нарын багууд 2004 оноос хойш төсөл хэрэгжүүлсэн 3 жилийн хугацаанд “Тогтвортой хөгжлийн төлөх боловсрол” олгох чиглэлээр явуулсан үйл ажиллагаагаа нэгтгэн “Бүтээлийн яармаг үзэсгэлэн” гаргаж, туршлагаа хуваалцав.



WWF for a living planet™



Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (SIDA)-ийн санхүүжилтээр энэхүү семинар зохиулав.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн эрхэм зорилго нь эх дэлхийн байгаль орчны доройтлыг зогсоож, хүн төрөлхтөн байгальтайгаа харилцан шүтэлцэж амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хяналтберийн газар
Амарын гудамж-4, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол Улс
Утас: +976-11-311659; Факс: +976-11-310237
И-мэйл: info@wwf.mn; Website: www.wwf.mn
www.panda.org

Дэлгэр Балтсан, Ч. Эрдэнэчимэг

Ханхуйс, Г. Содонжавчин

Хавтсан, Хеймарь хөвгөлийн газар

